



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2024 оны 05 сарын 31 өдөр

Дугаар 120

Бат-Өлзий сум

**Гэрээ байгуулах тухай**

Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсэг, 44 дүгээр зүйлийн 44.1 дэх хэсэг Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 3.3.7, 4.4.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Ажлын хэсгийн 2024 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн хуралдааны дүгнэлтийг үндэслэн Орон нутгийн хөгжлийн сангийн малын тоо толгойн албан татварын хөрөнгө оруулалтаар Улиастай 6 дугаар багийн Бөөрөгт худаг гаргах ажлыг “Хутагт-Уулын Өгөөж” хязгаарлагдмал хариуцлагатай компанитай шууд худалдан авах аргаар гэрээ байгуулсугай.

2. “Хутагт-Уулын Өгөөж” хязгаарлагдмал хариуцлагатай компанитай гэрээ байгуулж, худаг гаргах ажилд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Н.Бат-Эрдэнэ)-д даалгасугай.

3. Улиастай 6 дугаар багийн Бөөрөгт худаг гаргах ажилд шаардагдах 18,900,000 (арван найман сая есөн зуун мянга) төгрөгийг гэрээнд заасны дагуу Орон нутгийн хөгжлийн сангийн малын тоо толгойн албан татвараас зарцуулахыг Засаг даргын Тамгын газрын гэрээт нягтлан бодогч (Б.Пүрэвсүрэн)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



С.АМГАЛАН